



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 20 өдөр

Дугаар A/200

Мандалтова

Г Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг  
боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.6, 2, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.2, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 10 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, ажлын хэсгээс зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Орон нутгийн хамгаалалтын шинээр батлагдах төлөвлөгөөг боловсруулах ажлыг сайтар хангулж, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцлалын горимыг чанд сахих, хүн нэг бүрээр нууцын баталгаа гаргуулах, ажлын хэсгийн гишүүдийг үүрэг даалгавраар хангаж, зохион байгуулалтын удирдлагаар тасралтгүй ханган ажиллахыг ажлын хэсгийн дарга (Ж.Мөнхчuluун), Цэргийн штабын дарга дэд хурандаа (Ш.Гансүх) нарт даалгасугай.

Гурав. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг 2019 оны 5 дугаар саарын 31-ний дотор аймгийн Засаг даргаар хянуулж батлуулахыг ажлын хэсгийн дарга (Ж.Мөнхчuluун)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



488190530

Аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын  
-ний өдрийн дугаар захирамжийн нэгдүгээр  
хавсралт

**АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Д/Д	Ажлын хэсэг	Нэрс	Албан тушаал
1	Ажлын хэсгийн дарга	Ж.Мөнхчулун	Аймгийн Засаг даргын орлогч
2	Нарийн бичгийн дарга	Ш.Гансүх	Цэргийн штабын дарга, дэд хурандаа
3	Гишүүд	А.Ганбат, Х.Пүрэвмаа	Санхүү, төрийн сангийн хэлтсийндарга, мэрэгжилтэн
4		Б.Түвшинбаяр	Хууль эрх зүйн хэлтсийн дарга
5		О.Амарсанаа	Цагдаагийн газрын дарга, хурандаа
6		М.Адъбаатар	Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа
7		Э.Чагнаадорж	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга
8		Н.Гантулга	БОАЖГ-ын дарга
9		Г.Бат-Орших, Х.Жаргал	Эрүүл мэндийн газрбн дарга, аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга
10		М.Туяацэцэг	Татварын хэлтсийн дарга
11		Сумдын ЗДТГ-ын дарга нар	
12		Б.Энхтуяа	Статистикийн хэлтсийн дарга
13		Ц.Бямбацогт	Аймгийн авто тээврийн төв
14		Т.Энхцэцэг	Архив, бичиг хэргийн бичээч, оператор
15		Я.Мажаасүрэн	УЦУОША
16		С.Түвшинжаргал	Мэдээлэл холбоо сүлжээний дарга



Аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын  
20-ний өдрийн, 5 дугаар захирамжийн хоёрдугаар  
хавсралт

**ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ШИНЭЭР БОЛОВСРУУЛАХ  
АЖЛЫН ХЭСГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийгдэх арга хэмжээ	Огноо	Хариуцах албан тушаалтан	Хамрагдах бүрэлдэхүүн
1	Аймгийн Засаг даргын Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг бүрэлдэхүүнийг томилсон захирамж батлуулах	2019.05.17	Цэргийн штабын даргад/х.Ш.Гансүх	Цэргийн штабын офицерууд
2	Ажлын хэсгийн нэгдүгээр хуралдааныг зохион байгуулах /Аймгийн ЗДТГ-ын хурлын заал/	2019.05.21	Цэргийн штаб	Ажлын хэсгийн гишүүд
3	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөнд ашиглах судалгаа мэдээллийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс нэгтгэн авах	2019.05.21-31	Цэргийн штаб	Ажлын хэсгийн гишүүд
4	Ажлын хэсгийн гишүүдийн ирүүлсэн дүн, тоо баримтыг нэгтгэн дүн шинжилгээ хийх	2019.05.31	Цэргийн штаб	Ажлын хэсгийн гишүүд
5	Онц чухал объектын байршил, тооны судалгаа гаргах	2019.05.22-25	Цэргийн штабын даргад/х.Ш.Гансүх	Цэргийн штабын офицерууд
6	Орон нутгийн хамгаалалтын санхүүгийн зардал тооцоо	2019.05.25	Цэргийн штаб	Аймгийн Төрийн сангийн дарга А.Ганбат
7	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг аймгийн Засаг даргад танилцуулах	2019.06.01	Цэргийн штаб	Ажлын хэсэг

ТӨЛӨВЛӨСӨН: ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА

ДЭД ХУРАНДАА

Ш.ГАНСҮХ